



Монголын
Барилгын
Үндэсний
Ассоциаци

МОНГОЛ УЛСЫН
ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДАД

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

Монгол Улс, Улаанбаатар 15141, Чингэлтэй дүүрэг,
5 дугаар хороо, Самбуугийн гудамж 24,
МН Тайэр, 8-р давхар, 805, 806 тоот
Утас: +(976) 7011 1515
Утас: +(976) 7011 5055, +(976) 11 320974
И-мэйл: info@mnca.mn, Вэб: www.mnca.mn

2019. 04. 10 № 19/59

Танай -ны № -т

Хамтран ажиллах тухай

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь барилгын салбарт сайн засаглалыг бий болгоход төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, уялдааг сайжруулж, хууль эрх зүйн орчинд шинэчлэл хийхэд нэлөөлж, гишүүдийн чадавхийг сайжруулах, барилгын зах зээлийн тогтвортой өсөлтийг хангахад хувь нэмрээ оруулах эрхэм зорилготойгоор 2009 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд өдгөө барилгын салбарт үйл ажиллагаагаа явуулж буй томоохон хөрөнгө оруулагч, хөгжүүлэгч, барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэгч, зураг төслийн чиглэлийн 150 гаруй гишүүн байгууллагуудыг эгнээндээ нэгтгэн манлайлан ажиллаж буй ашгийн бус, салбарын мэргэжлийн төрийн бус байгууллага юм.

Энэ жил манай байгууллагын 10 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан ойн тэмдэглэлт үйл ажиллагааны хүрээнд бид Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургуультай хамтран оюутан залуусыг дэмжих “Шийдлийг санаачлагчид” буюу “Initiators of the Solution” тэмцээн-уралдааныг зохион байгуулахаар ажиллаж байна.

Иймд та бүхнийг бидний зохион байгуулж буй тэмцээн-уралдаанд тус сургуулийн оюутнуудыг өргөнөөр оролцуулан бидний үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллахыг хүсье.

Тэмцээний удирдамжийг хавсаргав.

Хавсралт 2 хуудастай.

Хүндэтгэсэн, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ЛХУДАН

Л.ХУЛАН
Он просил у меня
подарить его сыну
книгу о физике

САНААЧЛАН ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД



БИЗНЕСИЙН
СУРГУУЛЬ
МОНГОЛ УСЫН ИХ СУРГУУЛЬ

Хамтран зохион байгуулагчид



МОНГОЛЫН БАРИЛГЫН АССОЦИАЦИЙН 10 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ОЮУТАН ЗАЛУУСЫГ ДЭМЖИХ “ШИЙДЛИЙГ САНААЧЛАГЧИД” ТЭМЦЭЭН-УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Зорилго: Монголын их дээд сургуулиуд, Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, коллежийн оюутнуудыг дэмжих, барилгын салбарт нэвтрүүлэх шинэ санаа, дэвшилтэт технологийн шийдлийн төслүүдийг илрүүлж, тэдгээрт хөрөнгө сруулах, барилгын салбарын үйлдвэрлэл, технологийн чиглэлээр суралцагчдын практик дадлагыг сайжруулах, ажил олгогч, суралцагчдын хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлахад оршино.

Оролцогчид:

Их, дээд сургуулийн оюутан, магистрантууд
Барилгын болон бусад Политехник Коллежийн оюутнууд
Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагсад

Хугацаа: 201904 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 07-ны өдөр

Уралдаанд оролцогчдод тавигдах шаардлага:

- Барилгын үйлдвэрлэлд нэвтрүүлэх материалын, технологийн болон инженерийн шинэ дэвшилтэт шийдлийн санаа гарган, боловсруулан оролцох
- Уралдаанд оролцох баг инженер, техникийн мэргэжлийн оюутнуудаас бүрдсэн 3 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй байж болно.
- Оролцогч баг ментор багштай байж болно.

Үе шат:

Эхний үе шат /04.01-04.20/ – Уралдаанд оролцогчид технологийн шийдлийн санаа болон бүтээлээ их дээд сургуулийн багш нар, хөрөнгө оруулагчдын төлөөлөл бүхий шүүгчдийн бүрэлдэхүүнд 1-2 минутын дотор танилцуулна. Шүүгчид тэдгээрээс хэрэгжих боломжтой 15 санаа, бүтээлийг дараагийн шатанд шалгаруулна.

Зохион байгуулагчид эхний үе шатнаас шалгарсан 15 багийн санаа, бүтээлийг боловсронгуй болгох зорилгоор технологи, бизнесийн сургалт, зөвлөгөө явуулна. Санаа, бүтээлийг хөгжүүлэх хугацаа 14 хоног.

Хоёрдугаар үе шат /04.20-05.07/ – Уралдаанд оролцогчид бүтээлээ Монголын Барилгын Үндэсний Ассоциацийн гишүүн, хөренгө сруулагч, томоохон компаниудын төлөөлөл, их дээд сургуулийн багш нараас бүрдсэн шүүгчдийн бүрэлдэхүүнд танилцуулах бөгөөд шүүгчид ур чадвараараа тэргүүлсэн 3 багийг шалгаруулна.

Эцсийн үе шатыг олон нийтийн телевизтэй хамтран нэвтрүүлэг болгож цацна.

Шалгаруулалтын зарчим:

- | | |
|------------|--|
| 1-р үе шат | Шинэ бүтээлийн санал санаачилгыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломжийг харгалзан шүүнэ. |
| 2-р үе шат | Багийн санаа, бүтээл боловсруулалтын хөгжлийн байдал, эдийн засгийн үндэслэл, тооцоолол эдийн засгийн үр ашигтай байдлыг үнэлнэ. |

Шагналын сан:

- | | |
|-----------|---|
| I байр: | Бизнесийн санаа бүтээлээ хэрэгжүүлэх боломж (санхүүжилт, техникийн туслалцаа), 3 сая төгрөг |
| II байр: | Бизнесийн санаа бүтээлээ хэрэгжүүлэх боломж (санхүүжилт, техникийн туслалцаа), 2 сая төгрөг |
| III байр: | Бизнесийн санаа бүтээлээ хэрэгжүүлэх боломж (санхүүжилт, техникийн туслалцаа), 1 сая төгрөг |

Оюутнуудаа хамгийн идэвхтэй бэлтгэн оролцуулсан нэг багшийг шалгаруулан урамшуулна.

Шилдэг 15 багт ивээн тэтгэгч, дэмжигч байгууллагуудын нэрэмжит шагналыг гардуулна.